



УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТАМГЫН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
2023 ОНЫ НАМЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 07-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

# ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ТҮР ХОРООНЫ ХУРАЛДААН

## ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах  
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
**2023 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр, Мягмар гараг**

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	0
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	3-4
<hr/>	
<i>1.Горимын санал</i>	3-4

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы Хянан шалгах түр хороо /Эмийн үнийн өсөлтийн шалтгаан, нөхцөлийг хянан шалгах/-ны 11 дүгээр сарын 07-ны өдөр /Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Хянан шалгах түр хорооны дарга Ж.Чинбүрэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 7 гишүүнээс 4 гишүүн хүрэлцэн ирж, 57.1 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 34 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Томилолттой: Д.Батлут.

Түр хорооны дарга Ж.Чинбүрэн Хянан шалгах түр хорооны хянан шалгагч томилох учраас хуралдааныг хаалттай явуулах горимын санал гаргав.

**Ж.Чинбүрэн:** Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 4

Татгалзсан: 0

Бүгд: 4

100 хувийн саналаар горимын санал дэмжигдсэн тул 16 цаг 40 минутад хуралдааныг хаалттай горимд шилжүүлэв.

Нээлттэй хуралдаан 6 минут үргэлжилж, 7 гишүүнээс 6 гишүүн хүрэлцэн ирж, 85.7 хувийн ирцтэйгээр 14 цаг 40 минутад өндөрлөв

Тэмдэглэлтэй танилцсан:

ХЯНАН ШАЛГАХ ТҮР  
ХОРООНЫ ДАРГА

Ж.ЧИНБҮРЭН

Тэмдэглэл хөтөлсөн:  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

## **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ**

2023 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр,  
Мягмар гараг  
Төрийн ордон “Их засаг” танхим  
14 цаг 32 минут.

### **ТҮР ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

**Ж.Чинбүрэн:** Өдрийн амгаланг айлтгая. Эмийн үнийн өсөлтийн шалтгаан, нөхцөлийг хянан шалгах үүрэг бүхий Хянан шалгах түр хорооны гишүүдийн ирц бүрдсэн тул Түр хорооны 2023 оны 11 дүгээр сарын 7-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Түр хорооны ирцийг танилцуулъя Оюунчимэг гишүүн ирсэн байна, Жаргалмаа гишүүн ирсэн, Бейсен гишүүн ирсэн, Сандаг-Очир гишүүн ирсэн, Туваан гишүүн орж ирж байгаа юм байна.

Ингээд ирц хангалттай байна. Хэлэлцэх асуудлын талаар тайлбар хэлье. Өнөөдрийн хуралдаанаар Хянан шалгах түр хорооны хянан шалгагчийг нэмж нэг хянан шалгагч томилох ийм саналтай байгаа.

Бид 3 гишүүнийг томилсон. Энэ хүрээндээ өнөөдрийг хүртэл юу хийгдэв гэхлээр бид нарын өгсөн ажиллах, хянан шалгах ажлын цар хүрээний дагуу эмийн асуудалтай холбоотой төрийн байгууллагууд руу мэдээлэл өгөх шаардлага бичиг явуулсан байгаа. Үүнтэй холбоотойгоор Татварын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газраас мэдээллүүд ирж эхэлсэн.

Даатгалын ерөнхий газраас мэдээллүүд ирж эхэлсэн байгаа. Мэдээллийн ерөнхий агуулга юу бол их том асар их том. Нөгөө эмийн бүх Монгол Улсад гаалиар орж ирж байгаа эмийн үнэ энэ тэр орж ирж байгаа.

Тэгэхлээр энэ их том биг датаг хэрхэн авах талаар хүртэл бид цахимжуулж авах уу, цаасаар авах уу. Энэ тэр гээд л маш олон нарийн асуудлууд явж байгаа. Тэгээд бас хянан шалгагч нарын тоо 3 байхлаар үнэхээр хангалтгүй байна хүрэхгүй байна.

Тэгээд нэмээд одоо нэг хүнийг хянан шалгагчид оруулъя гэсэн ганцхан асуудлыг хэлэлцье гэдэг байдлаар та бүгдийн энэ хурлаа зарж та бүгдийг урьсан юм байгаа юм. Тэгэхлээр хэс хэлэлцэх асуудал бол нэг Хянан шалгах түр хорооны хянан шалгагчийг томилох асуудал байгаа юм.

Энэ дээр та бүхэн хэлэлцэх асуудал дээр өөр саналтай гишүүд байна уу? Нэмж ярилцах сэдэв байхгүй юу тэ? Байхгүй байхгүй.

Түр хорооны хянан шалгагч нарыг томилох тухай тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Түр хорооны хянан шалгагч шинжээч томилох нь Түр хорооны дотоод асуудал бөгөөд Хянан шалгах түр хорооноос томилогдсон ажиллагааг хянан шалгаж шинжээч нарт хөндлөнгөөс нөлөөлөх магадлалтай учраас хаалттай хуралдъя гэсэн горимын саналыг гаргаж байна.

Хянан шалгагчаар. Түүрүүн бид нэг 3-ыг томилчихсон байгаа. Тэрэн дээр нэмээд нэг. Тэгэхлээр энийг хаалттай горимд шилжүүлэх саналыг гаргаж байна.

Энэ Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2, 12.3 дахь хэсгийг тус тус үндэслэн хуралдааны хаалттай горимд шилжүүлэх горимын санал хураалт явуулъя.

Хаалттай хуралдъя гэдгийг дэмжиж байгаа хүмүүс саналаа өгнө үү.

*Санал хураалт дэмжиж байгаа.*

*Бүгдээрээ дэмжсэн байна.  
Баярлалаа.*

Ингээд хурлаа хаалттай горимд  
шилжүүлье.

*14:40 цагт*

ДУУНЫ	БИЧЛЭГЭЭС
ХУРАЛДААНЫ	
ДЭЛГЭРЭНГҮЙ	ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ,	
ХЯНАСАН:ШИНЖЭЭЧ	П.МЯДАГМАА